

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Дундговь аймаг

2021 оны 11 сарын 30

2021 онд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам болон Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймаг орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, удирдамж чиглэлийн хэрэгжилтийг ханган өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт үнэн зөв, түргэн шуурхай, шударга, хариуцлагатай эрхлэн зохион байгуулж үндсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэн төлөвлөсөн ажлаа биелүүлэн ажиллалаа.

1. УБЕГазраас өгсөн чиглэлийн дагуу хийсэн ажлаас :

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газар, Хяналт шалгалтын газар, Сонгуулийн ажлын хэсэг болон дотоод албан бичгээр ирүүлсэн 15 удаагийн өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулж тайлан мэдээг илтгэх хуудсаар хугацаанд нь өгч ажиллалаа.

- ❖ 2021.01.28-ны өдрийн А/59 тоот шилжилт хөдөлгөөн түр зогсоох тухай тушаалыг хүлээн авч иргэний бүртгэгч нарт танилцуулан иргэдэд мэдээллийг хүргэж ажилласан.
- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 8/699 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл болон Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд тус аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэний тоог Election.gasr.mn программаас гаргаж, 2021 оны 2 дугаар сарын 10-ний өдөр хэлтсийн даргын албан бичгээр тус аймагт байнга оршин суугаа хаягийн бүртгэлтэй 31394 сонгогчийн тоог баг тус бүрээр гаргаж аймгийн Иргэдийн хуралд хүргүүлсэн.
- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-ний 20 дугаар заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 2/699 тоот чиглэлийн 5 дугаар заалтын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дундговь аймгийн 15 сумын сонгуулийн хэсэг байгуулж, нутаг дэвсгэрийг зарласан, тогтоолын эх хувийг 2021 оны 02 дугаар сарын 23 өдрийн албан бичгээр Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.
- ❖ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дундговь аймгийн 15 сумын 68 багт сонгуулийн 52 хэсэг байгуулж, нутаг дэвсгэрийг зарласан, тогтоолыг <http://election.gasr.mn>-д шивж оруулан, сонгуулийн 52 хэсгийн санал авах байрны мэдээллийг шивж баталгаажуулсан.
- ❖ ИУБГ-ын ахлах бүртгэгч Н.Наранцэцэгийн өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэсгийн дугаар, хэсэг оноолтын мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалт, удирдлагын программд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоол, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын сонгуулийн хэсгийн дугаарыг тогтоосон тушаалтай тулган шалгаж илтгэх хуудсыг хүргүүлж ажилласан.
- ❖ ИУБГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу корона цар тахлын үед хэрхэн ажиллах талаарх судалгааг гаргаж 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр ИУБГ-т хүргүүлсэн.
- ❖ ИУБГ-аас өгсөн үүрэг даалгаврын дагуу МУЕСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.6-д заасан 6 байгууллагын мэдээллийг нягтлан шалгаж илтгэх хуудсыг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдөр ИУБГ-т хүргүүлсэн.
- ❖ ИУБГ-аас 2021 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 5/2985 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр ИУБГ-т хүргүүлсэн. УБЕГ-ын даргын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 1/3426 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хэрэгжилтийг ханган ажилласан.
- ❖ УБЕГ-ын 2021 оны 8/2225 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах тухай сумдын улсын бүртгэгч нарт мэдээлэл хүргүүлсэн.

- ❖ Иргэний улсын бүртгэлийн газраас е-майлээр өгсөн иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоосон тухай УБЕГ газрын даргын тушаал, 100-гаас дээш настны судалгааг ирүүлэх тухай, мэдээллийн санд тодорхойгүй төлөвтэй 9 иргэний бүртгэлийг тулган нягталж ирүүлэх тухай, Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн төлөвлөгөө, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийг харах эрхийг сумдад олгож байгаатай холбоотой зөвлөмж зэргийг улсын бүртгэгчдэд мэдээлж хугацаатай тайлан мэдээг хуулийн хугацаанд хүргүүлж улсын бүртгэгчдэд тухай бүр заавар зөвлөмж өгч ажиллаж байна.
- ❖ Иргэний улсын бүртгэлийн газраас дотоод сүлжээгээр түр оршин суугчийн мэдээлэл, гаргаж ирүүлэх чиглэлийн дагуу сумдын улсын бүртгэгчдээс холбогдох хүснэгтээр мэдээллийг гаргаж хүргүүлсэн.
- ❖ УБЕГ-ын даргын 2021 оны А/59 дүгээр тушаалаар МУИХ-ын сонгуулийн 28 дугаар тойрогт хамаарах нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан сумдын улсын бүртгэгч нарт Сонгинохайрхан дүүргийн тухайн тойрогт хамаарах хороодоос шилжин ирэх иргэдийн бүртгэлийг хөтлөхгүй байхыг анхааруулж, тушаалыг улсын бүртгэгчдэд хүргүүлэн ажилласан.
- ❖ Шинэ программын туршилтын саналыг 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдөр ИУБГ-т хүргүүлсэн.* Шинэ программ нэвтрэхтэй холбоотой 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдөр үнэт цаасны судалгааг ИУБГ-т хүргүүлсэн
- ❖ ИУБГ-ын даргын 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 4/7590 тоот албан бичгийн дагуу зорилтот бүлгийн 53 иргэний судалгааг хүргүүлсэн.
- ❖ 2021 оны 10 сарын 22 ны өдрийн А/706 тоот “Монгол улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспортын бэлдцийг хүлээн авах, олгох, зарцуулалтад хяналт тавих журам, А/707 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаас, маягтыг хүлээн авах, олгох зарцуулалтад хяналт тавих журмыг улсын бүртгэгчдэд танилцуулан мөрдөн ажиллаж байна.


2. Иргэний бүртгэлийн чиглэлээр:

2021 онд **11860** иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг хүргэж ажиллалаа. Тайлант хугацаанд ИГББүртгэлийн сар бүрийн тоон мэдээний нэгтгэлийг 12, иргэний үнэмлэхийн тайлан 12 удаа, бүртгэлийн үйлчилгээний орлогын тайланг 12 удаа нийт 36 удаа тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна.

2021 онд нийт **1917** иргэний үнэмлэх хэвлүүлж олгосноос шинээр **600**, хаяж үрэгдүүлэн дахин авсан **356**, хугацааны сунгалтаар **961** иргэнд иргэний үнэмлэх олгосон байна. 2021 онд төрөлтийн бүртгэл **893** хүүхэд, гэрлэлтийн бүртгэл **124**, үрчлэлт **12**, гэрлэлт цуцлалтын бүртгэл **29**, эцэг тогтоолтын бүртгэл **23**, ОНӨ бүртгэл **23**, нас барсны бүртгэлд **279** нийт **1383** бүртгэл, **1204** иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэж **2587** бүртгэлийн маягтыг мэдээллийн санд баталгаажууллаа. Гадаад паспорт шинээр захиалсан **63**, дахин захиалсан **73** нийт **133** иргэнд гадаад паспорт олгосон байна. Нийт **3851** лавлагаа хэвлэсэн бөгөөд хууль хяналтын байгууллагын хүсэлтээр **688** лавлагаа хэвлэж олгосноос цагдаагийн байгууллагын хүсэлтээр **386**, Авлигатай тэмцэх газрын хүсэлтээр **119**, Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн хүсэлтээр **168**, ШШГГазрын хүсэлтээр **15** лавлагаа, албан хэрэгцээнд улсын бүртгэгчид **296**, иргэнд **2867** лавлагаа олголоо. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлсэн **1317** иргэний бүртгэлийг мэдээллийн санд уншуулж хаягийн баталгаажилт, зургийн засварыг хийж иргэний үнэмлэхийг хэвлүүллээ. Эрүүл мэндийн яамны мэдээллийн сангаас регистрийн дугаарыг унагаж нийт **893** хүүхдийн төрөлтийн бүртгэлийг бүртгэсэн бөгөөд регистрийн дугаар зөрүүтэй олгогдсон **3** хүүхдийн




бүртгэлийг УБЕГазрын Мэдээлэл технологийн газар болон ЭМДГазарт албан тоотыг хүргүүлэн регистрийн дугаарыг засварлуулан дахин олгож бүртгэлийг хөтөлсөн.



2021 оны онцлог ажлуудаас:

- ❖ Азийн хөгжлийн банкнаас “ Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох “төсөл 2018 оноос үе шаттайгаар хэрэгжсэн. Энэ төслийн хүрээнд тус аймагт 2021 оны 1 сард Хулд, Луус сумдыг бүртгэлийн онлайн сүлжээнд холбосноор тус аймгийн 15 сум бүрэн сүлжээнд холбогдлоо. Сумд онлайнд холбогдсоноор иргэд орон зай, цаг хугацаанаас үл хамааран анхан шатан дээрээс бүртгэлийн үйлчилгээг хүртэх боломжтой болж байгаагаас гадна авч байгаа үйлчилгээний тоо нэмэгдэж байгаа юм.
- ❖ Монгол улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль 2021 оны 06 сарын 9-ний өдөр болсон. Сонгуулийн тухай хуулийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтад шилжин ирсэн 193, шилжин явсан 217, нас барсан 20, иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт 2, түр хасав сэргээсэн 2 нийт 434 лавлагаагаар сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлтийг тусгалаа. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар нийт 30331 сонгогч санал өгөхөөс 16178 сонгогч 53,3 хувьтай өгсөн байна. Хурууны хээгээр, регистрийн дугаараар 410 , зөөврийн хайрцгаар 357, түр хасав сэргээсэн 3, эрэгтэй 7298 эмэгтэй 8880, 18-19 насны 687 , 20-24 насны 1204, 25-26 насны 1350, 30-34 1593, 35-39 насны 1752, 40-44 насны 1735, 45-49 насны 1659, 50-54 насны 1593 55-59 насны 1440, 60-64 насны 1246, 65-69 насны 721, 70 аас дээш 1198 сонгогчийн санал өгөх эрхийг баталгаажуулан ямар нэг алдаа зөрчил гаргалгүй ажилласан.
- ❖ Улсын бүртгэлийн байгууллагын системийн хүрээнд 518 нэгжид БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй „Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-өөр иж бүрэн компьютер, олон үйлдэлт принтер, хурууны хээ уншигч, зургийн аппарат зэрэг тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн.



Энэ үйл ажиллагааны хүрээнд 2010 оноос хойш шинэчлэгдээгүй байсан тус аймгийн 15 сумын улсын бүртгэгчдийн тоног төхөөрөмж бүрэн шинэчлэгдэж бүртгэлийн үйл ажиллагаа анхан


шатанд хэвийн тасралтгүй хүрэх нөхцөл боломж бүрдсэн. Тоног төхөөрөмж шинэчлэгдсэнтэй холбоотой компьютерт программын тохиргоог мэдээлэл технологийн ажилтан хийлээ.

- ❖ Иргэний бүртгэлийн архивт хадгалагдаж байгаа хувийн хэргийн тооллогыг удирдамжийн дагуу 7 сарын 5-ны өдрөөс 9 сарын 10 ны хооронд архивч Э Мөнхсумъяа, гэрээт ажилтан Алтанзул, иргэний бүртгэлийн тасгийнхан зохион байгууллаа. Тооллогын зорилго нь архивт хадгалагдаж байгаа иргэний бүртгэлийн хувийн хэргийн цаасан суурьт баримтын нийт тоо бүртгэлийг гаргаж архивын эмх цэгцийг сайжруулан 2021 онд зохион байгуулагдах архивын улсын үзлэгт бэлтгэх зорилгоор зохион байгууллаа. Иргэний бүртгэлийн архивт хадгалагдаж байгаа 60 мянга гаруй иргэний хувийн хэргийг цахим сантай тулган нийт 1162 хайрцганд 145443 цаасан суурьт маягт хадгалагдаж байна.



- ❖ Улсын бүртгэгч Ш Чулуунжаргал нь санаачлан УБЕГазрын мэдээлэл технологийн газраас төрөлтийн бүртгэлийн мэдээлэл алдаатай буруу, дутуу бүртгэгдсэн 8200 иргэний жагсаалтыг гаргуулан авч мэдээллийн санд засварлуулах зөрчлийг арилгах ажлыг сумдын бүртгэгч нартай хамтран зохион байгуулж ажилласан бөгөөд улсын бүртгэгчид идэвх санаачлагатай сайн ажилласан. Энэ жилийн төлөвлөгөөнд 2050 бүртгэлийн зөрчлийг арилгахаар тусгасан бөгөөд өнөөдрийн байдлаар 102,5 хувь буюу 2100 төрөлтийн бүртгэлийн зөрчлийг арилгасан.

Энэхүү ажлыг зохион байгуулснаар цахимаас мэдээлэл авч байгаа иргэд, E-tolgolia системээс лавлагаа авч байгаа иргэд үнэн зөв мэдээ мэдээллээр хангагдахаас гадна заавал иргэн холбогдсон үед зөрчлийг арилгах биш урьдчилан зөрчлийг арилгаж ажиллах нь иргэд чирэгдэхээс урьдчилан авч байгаа арга хэмжээ болж байна.



4.Иргэний бүртгэлийн архивын үйл ажиллагаа:

2021 онд иргэний гэр бүлийн бүртгэлийн 1383 ИУБ-ийн маягтын Б талыг хүлээн авч бүртгэн архивын санд холбогдох журмын дагуу байрлууллаа. Шинээр 16 насанд хүрч биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгэгдсэн иргэдийн 600 ш маягт, мөн 25,45 насны хугацааны сунгалт хийлгэсэн 961 ш маягт нийт 1561 ИУБ- 31 маягтыг галиглан архивын журмын дагуу ИУБГазар болон, иргэний баримтын архивт жагсаалтаар хүргүүллээ. Иргэний гэр бүлийн бүртгэлийн мэдээний 1383 ш маягтын А талыг жагсаалтын хамтаар ИУБГазар болон архивт хүргүүлсэн

Өөр аймаг хотод шилжин явсан 735 иргэний хувийн хэргийг нийслэлийн улсын бүртгэлийн газар болон аймгуудад хүргүүлж, шилжин ирсэн 105 иргэний хувийн хэргийг жагсаалтын дагуу хүлээн авч галиглан архивын санд байршуулж байна.


Архивын эх нотлох баримтын хадгалалт хамгаалалт үнэ цэнийг дээшлүүлэх, журнал бүртгэлийн эдэлгээг уртасгах, хэрэглээг нэмэгдүүлэхэд анхаарч архивт хадгалагдаж байгаа иргэний гэр бүлийн журнал бүртгэлийг сэлбэн засах ажлыг өдөр тутамдаа хийж гүйцэтгэдэг.

Архивын улсын үзлэгт бэлтгэх, иргэний бүртгэлийн архивт хадгалагдаж байгаа хувийн хэргийн цаасан суурьт маягтын тоог нэг бүрчлэн гаргах архивын эмх цэгцийг сайжруулах зорилгоор иргэний бүртгэлийн тасаг, ахлах архивч Э Мөнхсумъяа, гэрээт ажилтан Алтанзул нар удирдамж боловсруулан 7 сарын 5-ны өдрөөс 9 сарын 10- ны хооронд хувийн хэргийг тоолж дуусгасан.

Иргэний бүртгэлийн хувийн хэргийн тооллогод архивт байрлагдаж байгаа А-Я хүртэлх үсгийн нийт **1274** хайрцгийн **60** гаруй мянган иргэний хувийн хэргийг хамруулж цахим сантай тулган өөр аймаг хот руу шилжин явсан, нас барсан **346**, тодорхойгүй төлөвтэй **245** иргэдийн хувийн хэргийг ялган цэгцэлснээр тус аймагт байнга оршин суугаа хаягийн бүртгэлтэй **45862** иргэний **1162** хайрцаг хувийн хэргийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан хаягжуулж, бүртгэлжүүлэн байршууллаа. Тооллогоор **45862** иргэний **1162** хайрцагны **145445** ширхэг цаасан суурьт ХААТР маягтууд хадгалагдаж байна.

Үүнд: ХААТР -1 /Хүн амын регистрийн карт/ - 18,969, Хаатр-1 маягт 5,251, ХААТР -11 /Төрсний бүртгэл/ - 27,069, ХААТР -21 /Иргэний үнэмлэх авах өргөдөл/ - 42,128, ИУБ -31 /Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл/ - 39,984, ХААТР -12 /Үрчлэлт/ - 396,ХААТР -13 /Овог нэр өөрчлөлт/ - 2,089,ХААТР -14 /Эцэг тогтоолт/ - 1,589, ХААТР -15 /Гэрлэлт/ - 7,097, ХААТР -16 /Гэрлэлт цуцлалт/ - 406, Маягт -25 Регистрийн дугаар өөрчлөлт - 29, ЗӨБ /Засвар өөрчлөлтийн бүртгэл - 438

Хувийн хэргийн тооллого хийх явцад өөр аймаг хот руу шилжин явсан **1597** иргэний хувийн хэргийг холбогдох газруудад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Тооллогын үеэр гарсан тодорхойгүй төлөвтэй **246** иргэний хувийн хэргийг тусгай сан үүсгэн байрлуулсан бол нас барсан **346** иргэний хувийн хэргийг нас баралтын санд байрлууллаа. Архивын хувийн хэргийн тооллогыг хийснээр архивт хадгалагдаж байгаа цаасан суурьт эх баримтын тоо бүрэн гарсан, архивын эмх цэгц, хадгалалт хамгаалалт сайжирсан үр дүнтэй ажил боллоо




5. Бүртгэлийн үйл ажиллагааны сурталчилгаа

- Иргэн, эд хөрөнгийн бүртгэлийн тасаг ТА-3 төсөл, модерн маркет ХХК-тай хамтран 2021.02.22-2021.02.26-ны өдрийн дуустал Өлзийт, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдад бүртгэлийн “Нээлттэй мэдээллийн өдөрлөг” зохион байгууллаа. Өдөрлөгөөр нийт **130** иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, **88** иргэнээс бүртгэлийн үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгааг бөглүүлж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

Тус сумдын улсын бүртгэлийн:

- ❖ 2020, 2021 оны бүртгэлд хяналт шалгалт хийх, заавар зөвлөмж өгөх.
- ❖ Өнгөрсөн оны бүртгэлийн баримт үдэж цэгцэлсэн эсэх,
- ❖ Дотоод сүлжээний компьютерт Спарк суулгах,
- ❖ Цахимжсан архивын программаас мэдээллийг хэрхэн хайж лавлагааг яаж гаргах


- ❖ Шинээр онлайнд холбогдсон сумд, шинэ бүртгэгчид программууд дээр хэрхэн ажиллаж байгаа,
- ❖ Ажлын байрны эмх цэгц,
- ❖ Бүртгэлийн үйл ажиллагааг орон нутагт хэрхэн сурталчилж, мэдээ мэдээллийг хүргэж байгаа,
- ❖ Мэдээллийн самбарын баяжилт өөрчлөлт зэрэг үзүүлэлтээр хяналтыг хийж заавар зөвлөмж өгч ажилласан. Цаашид бүртгэлийн үйл ажиллагааг орон нутагтаа сурталчлах, шинийг санаачилж манлайлж ажиллах, хууль тогтоомжийг уншиж судалж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хариуцлагатай ажиллахыг үүрэг болгож гарсан зөрчил дутагдлыг газар дээр нь арилган ажилласан.
- Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн хууль тогтоомжтой холбоотой цахим зөвлөмжийн 4 цуврал мэдээллийг бэлтгэж хүргэсэн. Нийт 760 иргэн хандалт хийж мэдээлэл авсан. Мөн улирлын зорилтын хүрээнд улсын бүртгэгчид Эрдэнэдалай, Адаацаг, Сайхановоо, Дэлгэрхангай, Дэлгэрцогт сумдын улсын бүртгэгч мэдээллийн фэйж хуудсанд хаяж үрэгдүүлсэн иргэний үнэмлэх хэрхэн авах, газар, үл хөдлөх хөрөнгийн анхны бүртгэл, компани хэрхэн бүртгүүлэх, шилжилт хөдөлгөөний бүртгэлээр “Live- мэдээлэл” хийж нийт 366 иргэн холбогдсон байна. Шинээр 16 насанд хүрч иргэний үнэмлэх авч байгаа Эрдмийн далай цогцолбор сургуулийн 10 Б ангийн 27 хүүхдэд “ Бүртгэгч-багш” мэдээллийн өдөрлөг зохион байгуулан иргэний шинэчилсэн бүртгэлд хэрхэн хамрагдаж иргэний үнэмлэх авах, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийг хэрхэн ойлгох талаар мэдээлэл өгч сэдвийн хүрээнд “АХА” танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулан түрүүлсэн сурагчийг дурсгалын зүйлээр урамшууллаа.



ghts

921 Post R

- Цаг үеийн нөхцөл байдалтай уялдан иргэдэд иргэний бүртгэлийн талаарх мэдээллийг түргэн шуурхай цаг алдалгүй хүргэх зорилгоор улсын бүртгэлийн үйлчилгээний лавлах утас **75052828** дугаарыг утсыг хэрэглээнд нэвтрүүлсэн. Бүртгэлийн лавлах -75052828 дугаарыг иргэдэд сурталчлах видео шторкийг бэлтгэж иргэдэд хүргэсэн
- Лавлах утсанд холбогдсоноор иргэн улсын бүртгэгчтэй шууд холбогдон мэдээлэл авах боломжтой болсон. E- mongolia цахим үйлчилгээний нэгдсэн системээс улсын бүртгэлийн үйлчилгээний 23 төрлийн лавлагаа мэдээллийг авах боломжтой бөгөөд цахим үйлчилгээг иргэдэд таниулан сурталчлах, бүртгэлийн үйлчилгээний талаарх лавлагаа мэдээлэл, иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспортыг онлайн аар захиалга хийх боломжтой иргэд өөрөө өөртөө үйлчилгээ авахад зориулсан „ Цахим



үйлчилгээний цонх,-ыг бүртгэлийн үйлчилгээний танхимд ажиллуулж байна. Улсын бүртгэлийн хэлтсийн “ ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ-ЦАГ ХУГАЦААНЫ ХЭМНЭЛТ” 1-р улирлын зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан “Бүртгэгчийн зөвлөмж” цувралыг цаг үеийн нөхцөл байдалтай уялдан иргэдэд бүртгэлийн хууль тогтоомжийн талаарх мэдээллийг сумдын дотоод фэйж хуудсанд 4 сумын улсын бүртгэгчид **Live-** мэдээлэл хүргэн иргэдийн сонирхсон асуултад шууд хариулт өгч ажилласан.



➤ Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” нээлттэй хаалганы өдөрлөг 2021 оны 10 сарын 13-ний өдөр болсон.Тус аймаг 2021 оныг “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан орон нугийн иргэдэд тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааны талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, байгууллагуудын үйлчилгээг иргэдэд нэг дороос үзүүлж, ард иргэдэд үйлчилгээгээ сурталчлан таниулах ” Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдсан.

Тус өдөрлөгөөр иргэний бүртгэлийн сүлжээг татан Сайнцагаан сумын улсын бүртгэгч Ш Чулуун газар дээр нь бүртгэлийн үйлчилгээг хүргэж ажилласан. Иргэний бүртгэлийн чиглэлээр гарын авлага тараах материалыг 68 иргэдэд хүргэн, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд 8 иргэн, төрөлтийн бүртгэлд 5 иргэн, иргэний үнэмлэх олголтын бүртгэлийг 23 иргэн, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 6 иргэн нийт 110 иргэнд үйлчилгээг хүргэлээ.



- олон нийтэд иргэний гэр бүлийн бүртгэлийн сар бүрийн статистик тоон мэдээгээр инфографик мэдээг бэлтгэн хэлтсийн олон нийтийн фэйсбүүк хуудас болон dundgovi@burtgel.gov.mn сайтад байршуулж хэвшсэн. Нийт 11 удаагийн инфографик мэдээлэл бэлтгэж хүргэсэн.

6. Сургалт: Зохион байгуулсан сургалт

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлийн байгууллагын итгэмлэгдсэн ажилтны эрх зүйн сургалтыг цаг үеийн нөхцөл байдалтай холбогдон цахимаар зохион байгууллаа. Сургалтаар Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Сонгогчдын нэрийн жагсаалт нягтлан шалгах, тулгах, давхардлыг



гч шилжих журам, төрийн албан хаагчийн ёс зүй, үйлчилгээний стандарт, итгэмжлэгдсэн ажилтны ажил үүргийн хуваарь зэрэг сэдвээр зөвлөмж, чиглэл өглөө. Сургалтад 52 итгэмжлэгдсэн ажилтан хамрагдлаа. 2021 оны 05 сарын 13-ны өдөр улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын нэгдсэн сургалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтаар 2020 онд хийсэн ажлын товч тайлан, 2021 оны зорилго зорилт авч хэрэгжүүлж байгаа ажлууд болон цаашид бүртгэлийн салбарт хийгдэх өөрчлөлт, анхаарах асуудал сэдвээр мэдээлэл өглөө. Мөн эд хөрөнгө, иргэн, хуулийн этгээд, бичиг хэрэг, архив, мэдээлэл технологи, санхүүгийн чиглэлээр холбогдох албан хаагчид powerpoint программ дээр мэдээллийг бэлтгэн албан хаагчдад хүргэсэн. Төрийн албан хаагчийн ёс зүй сэдвээр мэдээлэл өгч хэлтсийн ёс зүйн зөвлөлөөс гаргасан ёс зүйн гэрээг албан хаагчидтай байгуулан ёс зүйн зөрчилгүй, эрхэлсэн ажилдаа үнэнч шударга, хариуцлагатай албан хаагч байх тухай ёс зүйн гэрээ байгууллаа. Сургалтад нийт 26 албан хаагч хамрагдлаа.

- 2021 оны 05 сарын 30-ны өдөр итгэмжлэгдсэн ажилтны программын сургалтыг танхимаар зохион байгууллаа. Сургалтад Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, Аймгийн сонгуулийн хорооны дарга Л Доржбат оролцон бүртгэлийн байгууллагыг төлөөлөн ажиллаж байгаа итгэмжлэгдсэн ажилтнуудыг хариуцлагатай ажиллах, цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмээ сайн сахиж өөрсдийгөө эрсдлээс хамгаалан ажиллахыг хүслээ. Сургалтаар улсын бүртгэлийн байгууллагын Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар товч танилцууллаа. УБЕГ газрын хамтын ажиллагаа сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л Өнөртуяа МУЕС тухай хуулийн онцлог зохицуулалт, Сүхбаатар



дүүргийн хяналтын улсын байцаагч Л. Энхцэцэг Сонгогчдын нэрийн жагсаалт нягтлан тулгах, шалгах давхардлыг арилгах, сонгогч шилжих журам, Мэдээлэл технологийн газрын мэргэжилтэн Зориг сонгуулийн өдөр ирц бүртгэлийн программ дээр хэрхэн ажиллах талаар тус тус сургалт өгсөн. Сургалтаар сонгогчдын нэрийн жагсаалтад 434 лавлагаагаар холбогдох өөрчлөлтийг тусгаж СНЖагсаалтыг 3 хувь хэвлэн тамга тэмдгээр баталгаажуулж ажилласан. Сургалтад нийт 65 албан хаагч хамрагдсан.

- ❖ 2021 оны 09 сарын 24 ны өдөр иргэний бүртгэлийн шинэчилсэн систем хэрэглээнд нэвтэрсэнтэй холбоотой сумдын улсын бүртгэгчдэд чиглэл өгөх сургалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтаар системийн





ч танилцуулга, үнэт цаасны бүртгэлийн модулийн тухай, үнэт цаас худалдан авах, үнэт цаас хуваарилах, шилжүүлэх, жагсаалтаас хайх, нэгдсэн хайлт, иргэний гэр бүлийн бүртгэлийг бүртгэхэд анхаарах асуудлаар бүртгэгчдэд заавар зөвлөмж өгч ажиллалаа.

- ❖ 2021 онд Хулд, Говьугтаал, Луус, Өлзийт сумдын улсын бүртгэгчид шинээр

томилогдсонтой холбоотой ажлын байрны дадлага ажлыг Сайнцагаан сумын бүртгэгчийн ажлын байран дээр хийлгэн программ дээр дадлагажуулан ажиллаж байна. Мөн Цагаандэлгэр, Луус, Говьугтаал сумдын улсын бүртгэгчид ажлаас чөлөөлөгдсөн тул бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах зорилгоор харъяалал харгалздаг бүртгэлийг Сайнцагаан сумын улсын бүртгэгч Ш Чулуун, хэлтсийн иргэний улсын бүртгэгч Ё Батбаяр нар дээр давхар эрх нээлгэн бүртгэлийг хийлгэж байна.

УБЕГазраас зохион байгуулсан сургалт:

- ❖ УБЕГазрын Бодлого төлөвлөлт дүн шинжилгээний газраас 2021 оны 01 сарын 22-ны өдөр зохион байгуулсан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “ Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам ” болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217,218 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, цаашид анхаарах асуудлын талаарх сургалтад хэлтсийн ахлах бүртгэгчид, хяналтын улсын байцаагчид хамрагдсан.
- ❖ Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сонгуулийн тухай хууль тогтоомжийг таниулах, зөвлөмж чиглэл өгөх, итгэмжлэгдсэн ажилтнуудтай гэрээ байгуулахад анхаарах асуудлаар 2021 оны 05 сарын 10 ны өдөр цахимаар зохион байгуулсан сургалтад холбогдох албан хаагчид хамрагдсан. Сургалтаар сонгуулийн бэлтгэл ажлыг сайтар хангах, цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж чиг үүргийнхээ дагуу үйл ажиллагааны хэрэгжилтэд анхаарч ажиллахыг үүрэг болгосон.
- ❖ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлууд, мөн сонгогчийн бүртгэлийн программ хангамж, тониог төхөөрөмжийн ашиглалтын талаар мөн итгэмжлэгдсэн ажилтнуудад сургалт зохион байгуулах талаар чиглэл өгөх сургалтад 2021 оны 05 сарын 22-ны өдөр цахимаар зохион байгууллаа.Сургалтад ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагч нар хамрагдсан.
- ❖ 2021 оны 06 сарын 18-ны өдөр ИУБГазар, Интерактив компани зохион байгуулсан “Иргэний улсын бүртгэлийн онлайн болон оффлайн системийн нэгдсэн сургалт”-д сумдын улсын бүртгэгч, иргэний улсын бүртгэгч, ахлах бүртгэгч нар хамрагдсан. Сургалтыг онол дадлага, хослуулан, хамтын оролцооны арга зүйд түшиглэн суралцагчид санал бодлоо чөлөөтэй илэрхийлж бие биетэйгээ мэдээлэл чөлөөтэй солилцон нэгдсэн нэг ойлголтод хүрэх замаар сургалтыг зохион байгуулсан нь онцлог байлаа.
- ❖ 2021 оны 10 сарын 15 ны өдөр УБЕГазраас онлайнар зохион байгуулсан “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл” сэдэвт сургалтад хамрагдлаа.




- ❖ УБЕГазраас 2021 оны 10 сарын 26-ны өдөр гэмт хэрэг, терроризм, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан цахим сургалтад албан хаагчид цахимаар оролцлоо.
- ❖ 2021 оны 09 сарын 3- ны өдөр УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газраас иргэний бүртгэлийн ахлах бүртгэгчдэд онлайнаар сургалт өглөө. Сургалтаар нэгжүүдэд зөрүүтэй бүртгэгдэж байгаа бүртгэлийн талаар нэг мөр ойлголтод хүрч бүртгэлд хэрэглэх тухай чиглэл өгөх сургалтад хамрагдсан.
- ❖ УБЕГазраас орон нутгийн бүртгэлийн ажилтнуудад зохион байгуулсан нэгдсэн сургалт 2021 оны



08 сарын 22-23-ны өдрүүдэд “Сүм хөх бүрд”-д боллоо. Сургалтаар улсын бүртгэлийн багц хуулийн хэрэгжилттэй холбогдох дүрэм журам, улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал, байгууллагын хүний нөөц, сургалтын цахим системийн талаар сургалтын багийхан мэдээлэл хийлээ. Иргэний улсын бүртгэлийн газрын улсын бүртгэгч Ж. Нарантуяа иргэний улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал, Архивын мэргэжилтэн Байгалмаагийн “Цахим архивын программаас лавлагаа олгоход анхаарах асуудал” сэдвүүд үр дүнтэй мэдээлэл болсон. Сургалтад

нийт 23 албан хаагч хамрагдсан байна.

- ❖ Улсын хэмжээнд зохион байгуулагдсан Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаанд нийт албан хаагчид хамрагдсан. Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлийн шийдвэрээр “Монгол бичгээ эхлэн суралцах” цахим хичээлийг аймгийн хэмжээнд бүх төрийн албан хаагчдад явуулах зорилгоор “ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД” нэртэй фэйж хуудсанд элсэн монгол бичгийн цахим цуврал сургалтад хамрагдаж байна. Байгууллага бүрт монгол бичгийн багш хуваарилан хөтөлбөр сургалтын хуваарийн дагуу 7 хоногт 1 удаа хичээллэж байна. Монгол улсын гавъяат багш Д.Төмөрийн “Монгол бичгээ 15 хоногт бие даан сурах анхны хичээлүүд” номыг захиалан авч бичих дадлага хийж байна. УБЕГазраас зохион байгуулагдсан монгол бичгийн уралдаанд оролцлоо.



Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалт:

- ❖ 2021 оны 03 сарын 8 ны өдөр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Дундговь аймаг дахь Монгол банкны салбар, МЭХ-ны Дундговь аймаг дахь салбарын хамтран зохион байгуулсан “Өрхийн санхүүгээ удирдах нь амархан уу” сэдэвт сургалтад хэлтсийн эмэгтэй албан хаагчид хамрагдлаа. Сургалт нь эмэгтэйчүүдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хуримтлалын ашиг тусыг таниулах, бага орлогоос хуримтлал үүсгэх арга, өрхийн төсөвөө зөв удирдаж сурах нь зэрэг сэдвүүдээр зохион байгуулагдаж эмэгтэйчүүд гэр бүлийн төсөв санхүү, орлогоо хэрхэн нэмэгдүүлэх, хуримтлал



хэрхэн бий болгох, бие биеэсээ туршлага судлах, санаа авах зэрэг талаар чөлөөтэй санал бодлоо илэрхийлсэн сайхан сургалт боллоо.

- ❖ Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар, Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс хамтран МЕРИТ төслийн дэмжлэгтэйгээр Засгийн газрын 2020 оны 206,216,217,218 дугаар журмуудаар “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ сэдэвт 4 модуль сургалтыг зохион байгуулж уг сургалтад 4 албан хаагч оролцлоо.
- ❖ 2021 оны 05 сарын 4-ний өдөр зохион байгуулсан Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээ сэдэвт цахим сургалтад албан хаагчид онлайнаар хамрагдлаа. Энэ нь төрийн албан хаагчийг чадваржуулахад чиглэсэн үнэ төлбөргүй сургалт бөгөөд уг сургалтад хамрагдсанаар төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах аргачлалд суралцлаа. Нийт 18 албан хаагч сургалтад хамрагдан сертификат авлаа.



❖ Хэлтсийн албан хаагчдад “Гэр бүлийн хүчирхийллийн ойлголт” сэдвээр Цагдаагийн газрын гэр бүлээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Цэвэлмаа мэдээлэл хийлээ. Тус нийт 23 албан хаагч хамрагдсан сургалтад сумдын улсын бүртгэгчид онлайнаар хамрагдлаа.

❖ 2021 оны 11 сарын 15-ны өдрийн Канад улсын “MERIT” төслөөс цахимаар зохион явуулсан 1. Жендэр ба жендэрийн тэгш байдлын үндсэн ойлголт.

2. Ахисан түвшний жендерийн дүн шинжилгээ сэдвээр явуулсан 2 үе шаттай цахим сургалтанд 27 албан хаагч хамрагдаж Сертификатын болзол хангалаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр

ЭХЭУБГ-ын даргын 2021.04.14 –ны өдрийн 7/2734 тоот чиглэлийн дагуу засгийн газраас хэрэгжүүлж буй цогц төлөвлөгөөний хүрээнд жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгох жилийн 3 хувийн хүүтэй ажлын байрыг дэмжих зээл, ипотекийн зээлийг арилжааны банкууд бүх салбар нэгжүүдээрээ дамжуулан олгож байгаатай уялдан ипотекийн гэрээ болон өмнө бүртгүүлсэн гэрээний нэмэлт өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх иргэн, хуулийн этгээдийн хүсэлт сүүлийн өдрүүдэд огцом нэмэгдэж, иргэдийн бөөгнөрөл үүсгэх,



халдвар хамгааллын дэглэм зөрчигдөх, короновируст халдвар тархах өндөр эрсдэл үүсээд байгаа учир энэ эрсдлийг бууруулж, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор онцгой нөхцөл байдлын хугацаанд иргэн, хуулийн этгээдийн банктай байгуулсан барьцааны гэрээнүүдийг нэгтгэн банкны хариуцсан ажилтан улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхээр хандахад улсын бүртгэгч хүлээн авч бүртгээд банкны хариуцсан ажилтанд хүлээлгэн өгч ажиллах чиглэлийн дагуу ажилласан. Мөн лавлагааны нэгдсэн систем шинэчлэгдсэнтэй холбогдуулан нэвтрэх эрх болон системд ажиллах зааврыг авч зааврын дагуу ажилласан. Дундговь аймагт шинээр баригдаж ашиглалтанд орж буй барилгуудын

судалгааг 2019-2021 он хүртэл гаргаж 2021.04.15-ны өдөр ЭХЭУБГ- т хүргүүллээ.

Шинээр тус онд барилга барьж буй 7 аж ахуйн нэгж, иргэдийг 2021 оны 11 сарын 18 –нд кофетэй ярилцлага, уулзалт зохион байгуулж, үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх талаар дэлгэрэнгүй зөвлөлгөө өгч, бүгдэд нь хавтас гаргаж нотлох баримтуудыг дараалалаар нь хавтсандаа хийх санамж бичиг хийж ажилд нь туслаж ажиллалаа.

Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөж эхлэх бэлтгэл ажлын хүрээнд УБЕГ-аас ирүүлсэн асуулгын дагуу энэ жил эд хөрөнгийн бүртгэлийг оруулахаар төлөвлөсөн Эрдэнэдалай сумын бүртгэгч болон Эрдэнэдалай сумын 30 иргэнээс судалгаа авч УБЕГ-т хүргүүлж ажилласан.

Аймгийн төвийн нотариатчид, сумдын засаг даргын тамгын газрын дарга нартай эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системийн шинэчлэлийн талаар мэдээлэл, чиглэл өгч хамтарч ажиллаж байна. Аймгийн нотариатчидтай хамтран мэдээлэл солилцож барьцааны гэрээ болон бусад гэрээг хүлээн авч дундын мэдээллийн сангаар дамжуулан хянаж гэрээ баталахад бэлэн болсон. Нотариатчийн мэдээллийн сантай холбогдон, илгээсэн мэдээллийг хүлээн авах, бүртгэх, гэрээ байгуулах, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг эхлүүлэхээр нотариатч нартай хамтран ажиллаж байна.

МУ-ын ХЗДХийн сайдын зөвшөөрлийн загвар батлах, нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинэчлэн олгох тухай тушаалыг тасгийн бүртгэгчиддээ танилцуулан мөрдөж ажиллаж байна. Үнэт цаас санхүүжилтийн корпорациас 2021 оны 11 сарын 04-ний өдрийн 97/21 тоот хүсэлтийн дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг төрийн банкны хоёр бүртгэлийг бүртгэв.


Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг нийт **3519** мэдүүлэг хүлээн авч бүртгэл хийснээс **612** анхны бүртгэл, эрх шилжүүлэх **525** бүртгэл, бүртгэлд өөрчлөлт **93**, барьцааны гэрээ **2166**, барьцааны гэрээ дуусгавар болох **907**, лавлагаа 216-ийг бүртгэж, **460** иргэн, аж ахуйн нэгжид Э-дугаар олгож, үйлчилгээний хураамж **39 104 580** төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого **137 582 934**, тэмдэгтийн хураамж **1 230 702** төгрөг нийт улсын төсөвт **177 918 216** мянган төгрөгийн орлого орууллаа.

Тайлант хугацаанд тус аймагт нийт **57** орон сууц, **75** хувийн сууц, **25** авто зогсоол, **13** үйлчилгээ, **7** агуулах бүртгэгдсэн байна.

Сар бүр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээг ePRS цахим программаас төрөл төрөлөөр нь гаргаж, орлогын мэдээг шивж нягтлан бодогчид өгөх, info мэдээг тус сарын тоон мэдээг өмнөх оны тоон мэдээтэй харьцуулан гаргаж өссөн дүнгээр хэлтсийн мэдээнд оруулж хэвшлээ. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь тасгийн хурлыг дөрвөн удаа хуралдуулж, ЭХЭУБГ-аас ирүүлсэн чиглэлийг хэлэлцэх, улсын бүртгэгчдийн ажил үүрэгт чиглэл өгөх, бүртгэлд хяналт хийж зөвлөн туслах болон дотоод асуудлуудыг цаг тухайд нь шийдвэрлэж ирсэн.

Эд хөрөнгийн улсын бүртгэлийн цахим системд бүртгэлийн төрөл, эд хөрөнгийн төрөл буруу сонгож бүртгэл хийгдсэн болон бусад засвар өөрчлөлт хийгдэх мөн улсын бүртгэлийн гэрчилгээ үрэгдүүлсэн бүртгэлүүдэд хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан ахлах бүртгэгч засвар өөрчлөлтийн программ дээр засвар өөрчлөлт хийж ажиллаж байгаа нь бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, иргэдийг чирэгдүүлэхгүй ажиллахад ихээхэн ахиц гарсан.

2021 оны 10 сарын 13 өдрийн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч О.Ганцэцэг болон улсын бүртгэгч Н.Уугантуяатай хамтарч аймгийн төвийн Сайнцагаан сумын Ү-ширхэг хувийн хэрэгт цахим тулгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ ажлын хүрээнд Ү-0814000001ээс Ү-0814002905 хөдлөх хөрөнгө нийт 2905 хувийн хэрэгт төрлийн үзүүлэлтээр цахим тулгалтыг хийлээ. Тулгалтын явцад дараах алдаа, зөрчил илрүүлж ажиллалаа.



2905

үл
6-н

ҮҮНД:

1. Нэгж талбарын дугааргүй бүртгэл- 271 үл хөдлөх хөрөнгө байгаа боловч програмд бүртгэл хийгдэхээс өмнөх бүртгэл учир дараагийн бүртгэл ороход нэгж талбарын дугаар оруулж бүртгэхэд анхаарах шаардлагатай.
2. Хаяг давхардсан -196 үл хөдлөх хөрөнгө байна. /2018 оны цахимжуулалтын ажлын явцад нийт байрны хаягаас гудамжийг нь оруулаагүй цахимжуулсан үл хөдлөх хөрөнгийн тоо/
3. Нотлох баримт дутуу – 281
4. Дугаарлалтын алдаатай –49
5. Андуурч бүртгэсэн бүртгэл – 5
6. Цахимд ороогүй хувийн хэрэг -3 хувийн хэрэг байна. / ү-0814000945, ү-0814001589, ү-0814001672 хувийн хэргийн эх нотлох баримт нь тус хэлтсийн архивт байгаа болно.
7. ү-0814002794 тоот хувийн хэрэг тус хэлтсийн архивт цаасан баримтаар огт байхгүй бөгөөд цахим санд бүртгэгдээгүй байх тул нэн яаралтай тодруулах/

Архивын мэдээг сар бүр гаргаж ажилласан. Газрын **10764**, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн **4017**, газар эзэмших **1708** хувийн хэрэг нийт **16622** хувийн хэрэг архивт нээгдэн хадгалагдаж байна. Хэлтсийн архивт хадгалагдаж буй эд хөрөнгийн хувийн хэрэгт тооллого хийх ажлыг архивч Э.Мөнхсумъяагийн ажил хүлээлцэхтэй хамтруулан зохион байгууллаа. Нийт 2021 оны 06 сарын 02-ны байдлаар 14384 хувийн хэрэг байснаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 3931, газрын анхны бүртгэлийн 10453 ш хувийн хэрэг тоологдсон.

Сар бүрийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний мэдээг инфографикт оруулж өмнөх оны мөн үе, энэ оны мөн үетэй харьцуулж мэдээлэл бэлтгэн аймгийн сайтад байршуулсан.

Дундговь аймаг дахь ШШГГ, Цагдаагийн байгууллага болон бусад эрх бүхий албан байгууллагуудад нийт **216** үл хөдлөх хөрөнгийн лавлагаа, албан тоотын хариуг хүргүүлэн, хувийн хэрэгт нь хавсарган ажилласан **6** үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг түдгэлзүүлж **21** эд хөрөнгийн эрхийг сэргээж ажилласан.

Дундын мэдээллийн сангаас нийт 460 Э дугаар олгож хувийн хэргийн бүрдүүлэлтийг бүрдүүлж ажиллалаа. Тус бүрээр ангилвал Сайнцагаан -375, Адаацаг сум 54, Луус сум 35, Хулд сум 20, Дэлгэрхангай сум 1, Сайхан-Овоо сум 32, Эрдэнэдалай сум 155, Дэлгэрцогт 128, Дэрэн 13, Говь-Угтаал 42, Цагаандэлгэр 55, Баянжаргалан 45, Өндөршил 231, Гурвансайхан 124 тус тус олгосон байна.



Сумдаас ирүүлсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нотлох баримт, материалуудыг хүлээн авч мэдээллийн санд шалгаж үнэн зөв алдаагүй бүртгэлийг цахим мэдээллийн санд оруулж бүртгэлийг хөтөллөө. Нийт эд хөрөнгийн бүртгэлийг Сайнцагаан-**452**, Эрдэнэдалай-**48**, Гурвансайхан-**18**, Адаацаг-**13**, Дэлгэрцогт-**13**, Хулд -**11**, Сайхан-Овоо-**10**, Дэрэн-**8**, Өндөршил-**8**, Говь-Угтаал-**7**, Дэлгэрхангай-**6**, Цагаандэлгэр-**6**, Баянжаргалан-**1**, Өлзийт-**0** Луус- тус бүр явуулж бүртгүүлсэн байна. Дэрэн сум нь 2021 онд үл хөдлөхийн 27 бүртгэл хийсэн байна. Үүнд: Газар өмчлөх-19 Үл хөдлөх хөрөнгийн -2, үл хөдлөх хөрөнгө

барьцаанаас чөлөөлөх-6 бүртгэл хийж гэрчилгээг өмчлөгч, эзэмшигч нарт олгосон байна. 2021 онд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхан шатны болон бэлэглэх, худалдах худалдан

авах эрхийн материалыг хүлээн авч эд ажиллаа. Нийт Гурвансайхан сум 23 ЭХЭУБ-ийн мэдүүлгийг хүлээн авсан байна. Үүнд: Үл хөдлөх эд хөрөнгө шинээр бүртгүүлэх-2, шинээр газар өмчлөх-13, өвлөх эрх нээлгэх -1, хаяг хэмжээ өөрчлөгдсөн -2, худалдах худалдан авах гэрээгээр-2, бэлэглэх гэрээ -2, эрх шилжүүлэх-1. Нийт 19 гэрчилгээ олгосон. Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ -4, газар өмчлөх гэрчилгээ -15 -г тус тус олгосон.

Шинээр томилогдсон Хулд, Өлзийт сумын улсын бүртгэгчдэд эд хөрөнгийн бүртгэл хийхэд анхаарах асуудлууд, мэдүүлэг хүлээн авч хэлтэсд дамжуулах, буцааж сумандаа хэрхэн авах болон бусад зөвлөлгөөг өгч нэг өдрийн дадлага хийлгэсэн.

ГХБХБГ-ын даамлуудаас онлайнаар ирүүлсэн эзэмшлийн Э дугаар олгох эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нотлох баримт, материалуудыг хүлээн авч мэдээллийн санд шалгаж, цахим мэдээллийн санд Э дугаар олгож ажиллаж байна. Хариуцсан сумдын даамлуудад арга зүйн туслалцаа үзүүлж, утсаар холбогдон зарим сумдтай видео дуудлага хийж хувийн хэрэг материалд тулгалт хийж алдаатай баримтыг засч залруулах арга хэмжээ авч хамтран ажилласан. ЭХЭУБГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу хувийн хэрэг үүсгэлтийг хийхгүй товч мэдээллийг мэдээллийн сангаас хэвлэж, архивийн нэгж үүсгэн үдэж архивт хадгалахаар болон ажиллаж байсныг гуравдугаар улирлаас газар эзэмшлийн Э дугаар УБЕГ –аас автоматаар унадаг болсон.



Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх банкны салбаруудын ахлах зээлийн эдийн засагч нартай зангиагүй уулзалт зохион байгуулж цар тахалтай нөхцөлд ажиллахдаа бүх барьцааны гэрээг зөвхөн банкны эдийн засагч нараар дамжуулан зээлийг батлаж цар тахлаас урьдчилан сэргийлж ажиллах дээд газрын чиглэлийг мөрдлөг болгож ирлээ.

Онлайнаар сургалтанд хамрагдсан байдал: УБЕГ-ын ЭХЭУБ-ийн газраас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, дүрэм, журмын дагуу эд хөрөнгийн бүртгэл хөтлөх, дээрх хууль, дүрэм журмыг баримтлан бүртгэл хөтлөх талаар чиглэл өгөх сургалт 2021 оны 03 сарын 17-ны өдөр зохион байгуулагдлаа. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт онлайнаар зохион байгуулагдсан сургалт нь 2020 оны 12 сарын 30-ны өдрийн ЗГ-ын 246 –р тогтоолоор батлагдсан албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамтай сайтар танилцаж, мөрдөж хэрэгжүүлж ажиллах, засвар өөрчлөлтийн эрхийг бүх тасгийн дарга нарт олгосонтой холбогдуулан аливаа засварыг Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр засвар хийх гэх мэт 20 асуудлаар чиглэл өгсөн онлайн сургалтанд хамрагдан чиглэлийг мөрдөж ажиллаж байна.

УБЕГ-ын ЭХЭУБГ-аас 2021 оны 06 сарын 04-нд эд хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаа болон лавлагааг –PRS2 –оор олгох, эд хөрөнгийн бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд хамруулсан компанийн мэдээлэл, гэрээний эрх зүй гэсэн сэдвүүдээр явагдсан онлайн сургалтанд хамрагдсан.

2021 оны 03-р сарын 31 –нд эрхийн улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх, хүчингүй болгох, хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавих, цуцлах бүртгэлд анхаарах асуудлууд сэдэвт цахим сургалтанд хамрагдлаа.

УБЕГ-ын ЭХЭУБГ-аас 2021 оны 08 сарын 23-нд УБЕГ аас сургалтын баг ирж нийт алба хаагчдад танхимын сургалтыг Сүм хөх бүрд дээр зохион байгуулсан. ЭХЭУБГ-ын дарга ирж эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл, чиглэл өгсөн. Мэдүүлгийг шууд программаас хэвлэж, гарын үсэг зуруулан хүлээж авах, яаралтай бүртгэл бүртгэхгүйтэй холбодуулан мэдүүлэг хүлээн авсан дарааллыг хатуу чанд баримтлаж бүртгэл хийх, УБЕГ-ын ЭХЭУБГ-аас 2021 оны 09 сарын 06-нд эд хөрөнгийн бүртгэлийн үйл



ажиллагаа, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хууль зүйн сургалт сурталчилгааны төвийн дарга нотариатын үйл ажиллагаа, захиалгын гэрээ, дундын мэдээллийн сангаас мэдээлэлтэй ажиллах талаар дэлгэрэнгүй зөвөлгөө өгсөн. 2021 оны 10 сарын 14 ний өдрийн Улсын бүртгэлийн ерөнхий газраас байгууллагын аюулгүй байдлыг хангах зорилгоор зохион байгуулсан Галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай анхан шатны мэдлэг олгох ОНЛАЙН сургалтанд хамрагдсан.

ЗГХЭГ - аас онлайнаар явагдсан Үр дүнд суурилсан төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ сэдэвт шаталсан сургалтанд 2021 оны 05 сарын 05 –ны өдрөөс хамрагдаж сертификат авсан.

Мерит төслөөс онлайнаар явагдсан жендерийн сургалтанд сууж шалгалт өгч сертификат авах эрхтэй болсон.

Боловсрол соёл урлагийн газраас цахимаар явуулж байгаа монгол бичгийн сургалтыг бие дааж судлаж, Чоймоо багшийн номыг сургалтандаа хэрэглэн мэдлэг сайжирч байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

Хуулийн этгээдийн бүртгэл дахин гэрчилгээ олгосон 26, Нэмэлт өөрчлөлт хийсэн 109, Лавлагаа олгосон 268, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр хяналтын дугаар олгосон 80, шашны байгууллага хугацаа сунгасан 1, хураан авсан тамга тэмдэг 18, шинээр хуулийн этгээд бүртгүүлсэн 54, татан буугдсан 6, нэрийн баталгаажуулалт 55, хориг тавьсан 8, салбар төлөөлөгчийн газар 7 бүртгэлийг бүртгэж нийт 632 бүртгэл хийж нийт улсын бүртгэл хөтөлсөн байна. Тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих лавлагаа олгох журам"-д зааснаар татан буугдсан, хэлбэр өөрчилсөн, гэмтээсэн, оноосон нэр өөрчлөгдсөн шалтгаанаар нийт 18 тэмдэг хураан авч устгалд оруулсан.

Хуулийн этгээдийн бүртгэлд холбогдолтой 71 албан бичиг ирснээс ирсэн бичиг 30, явсан 41 бичгийг хууль хяналтын байгууллагад өгч үүнээс хориг тавих 3 харилцсан албан бичиг байна. Мөн хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэлгүй эсэх, дэлгэрэнгүй лавлагааг 268 иргэнд гаргаж өгсөн.

Монгол улсын засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23- ны өдрийн №230 тогтоолыг 2021 оны 07 сарын 01-ны өдөр мөрдөж эхэлснээс хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр орон нутгийн орлогод 6451000 мянган төгрөгний орлого төвлөрүүлсэн.

УБЕГ-н 2021 оны 03 сарын 22-ны өдрийн Б/1890 тоо дугаартай албан бичгийн дагуу улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлгүй, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй төрийн бус байгууллага 64, Хэвлэл мэдээллийн байгууллага 6, ҮЭБ 3, шашны байгууллага 4 нийт 80 хуулийн этгээдийн судалгааг хүргүүлсэн. Мөн аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Адъяасүрэнтэй хамтран тулгалт хийж сангийн яамын мэдээлэлд бүртгэлгүй аж ахуй нэгжийн бүртгэлийг тулгаж, архивд байршиж байсан шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн хувийн хэргийг хавтаслаж, татварын мэдээллийн сантай тулгалт хийж татан буулгах, бүртгэлд хамруулах ажлыг бэлэн болгосон.

Хяналтын чиглэлээр

2021 онд Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжийн хүрээнд нийт 278 шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт хийж нотлох баримтын бүрдэл дутуу байсан 23 бүртгэлийн зөрчлийг улсын бүртгэгчдээр арилгуулж ажилласан.

Иргэний бүртгэлийн чиглэлээр 38, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 16, хуулийн этгээдийн чиглэлээр 2 нийт 56 хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргалаа. ЭХЭУБүртгэлийн хувийн хэргийг цахим сантай тулгах 2500 бүртгэлд хэлтсийн даргын удирдамжийн дагуу анхан шатны хяналт тулгалт хийгээд байна. Илэрсэн программын алдаанаас үүдэлтэй зөрчлийг арилгах талаар ЭХЭУБГазарт хүсэлт гаргаж залрууллаа. Бүртгэгчийн цахимжуулалтын явцад хийсэн алдаа 5 илэрснийг залруулах арга хэмжээ авлаа. Нийт 2896 бүртгэлд хяналт хийлээ.

Санхүүгийн чиглэлээр

Тус хэлтэс нь УБЕГ-ын Даргын тушаалаар үндсэн 26, гэрээт албан хаагч 2, 2 орон тоо дутуу нийт 28 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Тус хэлтсийн 2020 оны жилийн эцсийн

санхүүгийн тайланд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар 2021 оны 1 дугаар сард аудит хийж санхүүгийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.

2021 оны 2-р улиралд нэмэлт санхүүжилтээр УБЕГ-ын Даргын 2021 оны 3-р сарын 18 өдрийн А/176 тоот тушаалаар батлагдсан 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардалд 50,716.7 мянган төгрөгийн санхүүжилт авч 50,716.7 мянган төгрөгийг сонгуулийн Итгэмжлэгдсэн ажилчдын цалин, тээвэр шатахуун, сургалт, албан томилолтын зардалд 100 хувь зарцуулсан.

УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст 2020 оны жилийн эцэс болон 2021 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу хуулийн хугацаандаа хүргэгдэж нэгтгэгдсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2021 оны 1-р улиралд тус хэлтсийн 2020 оны өмчийн мэдээ, захиргааны статистик маягтыг нөхөж хугацаанд нь хүргүүлсэн. ТӨБЗГ-т 2020 оны Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг холбогдох бусад баримтыг цахимаар хүргүүлж, 2021 оны 10 дугаар сарын 14 өдөр тус газраас гэрээний биелэлтийн дүнг маш сайн буюу 95 хувь дүгнэсэн.

Батлагдсан төсвөөс 365,693.8 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч, үүнээс цалин хөлсний зардалд 300,976.1, унаа хоолны зардалд 5,727.2, нийгмийн даатгалын шимтгэлд 40,194.2, бичиг хэргийн зардалд 1,465.7, тээвэр шатахууны зардалд 1,877.1, шуудан холбооны зардалд 1,662.9, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 100.0, даатгалын зардал 120.0, тээврийн хэрэгслийн татвар 52.4, тээврийн хэрэгслийн оношилгоо 22.0, дотоод албан томилолтын зардалд 165.0, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 4,326.3, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлд 931.2, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, төлбөр хураамжийн зардалд 963.2, урсгал засварын зардалд 46.0, газрын төлбөр 52.3, нийт 358,434.9 мянган төгрөгийг тус тус зарцуулж, төсвийн гүйцэтгэл 98%-тай байна.

2021 оны 1, 2, 3-р улиралд цар тахалтай холбоотой сангийн яамнаас тус хэлтсийн 2021 оны батлагдсан төсвийн цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байрны түрээсийн зардлаас бусад зардлыг 50-75 хувь хүртэл бууруулж олгож байна.

УБЕГ-аас тус хэлтсийн 2021 ийү үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 70,000.0 мянган төгрөгөөр баталсан. 11-р сарын 30-ны өдрийн байдлаар орлогын төлөвлөгөөгөөр 64,166.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээс, 77,489.4 мянган төгрөг төвлөрч, жилийн орлогын төлөгөө 110.7 хувьтай байна. 77,489.4 мянган төгрөгийг улсын төсөвт 100 хувь төвлөрүүлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон үйлчилгээний орлогын 1-р сараас 11-р сарын мэдээг тус бүр 11 удаа УБЕГ-т хүргүүлсэн. Нийгмийн даатгалын шимтгэлийн 1-р сараас 11-р сарын тайланг сар бүр нийт 11 удаа, 2020 оны 4-р улирал, 2021 оны 1, 2, 3-р улирлын татварын тайланг цахимаар тоон гарын үсгээр баталгаажуулан улирал бүр нийт 4 удаа гаргаж харъяа байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн. Тус хэлтэс нь 2021 оны 3-р улиралд АЗДТГ-ын ХШҮДАХ-ээс хийсэн шалгалтад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр 100 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн. Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 11 дүгээр сарын 30 өдөр хүртэлх хугацаанд нийт 122 мэдээлэлийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 122 мэдээллийг хугацаа хоцролгүй үнэн зөв, бүрэн байршуулж 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Хэлтсийн даргын 2021 оны 06 сарын 23 өдрийн А/23 тоот тушаалаар хагас жилийн бараа материалын тооллогыг зохион байгуулж 7 нэр төрлийн 28,164,972 төгрөг 38 мөнгөний үнэ бүхий бараа материал тоолж, тооллогоор илүүдсэн дутагдсан бараа материал байхгүй. Бараа материалын тооллогын үр дүнтэй Өмч хамгаалах байнгын зөвлөл танилцсан. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2021 оны 11-р сарын 18-ны өдөр хуралдаж 2021 онд захиргааны акт өөрчлөгдсөнтэй холбоотой цаашид ашиглагдахгүй болсон 20 нэр төрлийн 7,713 ширхэг 2,096,251 төгрөгийн үнэ бүхий үнэт цаасыг актлаж данс бүртгэлээс хасах, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага “Койка”-ийн санхүүжилтээр “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн хүрээнд бий болсон 8 нэр төрлийн 106 ширхэг 142,198,210 төгрөгийн үнэ бүхий компьютер, тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд орлого авах данс бүртгэлд тусгах тухай ТӨБЗГ-ын 2021 оны 10 дугаар сарын 18 –ны өдрийн А-1/1694 тоот албан бичигтэй танилцаж дээр дурдсан хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох

бүртгэлд тусган дүнг 2021 оны 4-р улиралд багтаан ТӨБЗГ-т хүргүүлэх тухай хуралдаж шийдвэрлэсэн. 2010 оны Иргэний шинэчилсэн бүртгэлд ашиглагдаж эхэлсэн тус хэлтсийн дансанд бүртгэлтэй 4 нэр төрлийн 47 ширхэг 43,099,070 төгрөгийн үнэ бүхий анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй, хуучин тоног төхөөрөмжийг УБЕГ-т хүргүүлж хэлтсийн данс бүртгэлээс хасуулах санал, албан тоотын хамт хүргүүлэн ажилласан.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж байна. УБЕГ-ын СААХ, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс зэрэг газруудад сар, улирал бүр тайлан, мэдээ, үнэт цаасны зарцуулалтын тайланг хуулийн хугацаанд хүргүүлж, баталгаажуулан харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэн ажиллаж байна.

УБЕГ-аас олгосон үнэт цаас, маягуудыг тухай бүр орлого авч сар бүрийн зарцуулалт, үлдэгдлийн мэдээ тайланг гаргаж, үйлчилгээний орлогыг төрийн сангий н дансанд төвлөрүүлэн сар бүр улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна. УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст сар бүрийн 2-ны дотор төсвийн гүйцэтгэлийн мэдээ, цахим үнэмлэхний орлогын мэдээ, сар бүрийн 30-ны дотор бүртгэлийн үйлчилгээний орлогын мэдээг тус тус гарган хүргүүлж ажиллаж байна. Тус хэлтэс нь 2021 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар өр, авлагагүй ажиллаж байна.

2021 оны ШИНЭЛЭГ АЖИЛ

Монгол улсын Ерөнхий сайдын ивээл дор 19 дэх жилдээ уламжлал болон зохион байгуулагдсан "ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА"-ын Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны баярын өдөр зохион байгууллаа. Уг ажиллагаанд ерөнхий боловсролын 5 сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 16 насанд хүрсэн нийт 51 сурагч иргэний үнэмлэхээ гардан авлаа. Ёслолын ажиллагаанд аймгийн засаг дарга Ц. Мөнхбат, Иргэдийн хурлын дарга С.Од-Эрдэнэ, аймгийн орлогч дарга М. Анхбаяр нар оролцож иргэний үнэмлэхээ гардан авсан сурагчдад иргэний үнэмлэхийг гардууллаа. Мөн Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга асан Ө.Шижир сурагчдад баяр хүргэн дурсгалын зүйл гардууллаа.

Шинээр гэр бүл болж байгаа залуу гэр бүлд гэр бүлийн боловсрол, соёлыг дээшлүүлэх залуу гэр бүлийн үүрэг хариуцлага, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, гэр бүлийн үнэ цэнэ, гэр бүлээ батлуулахын утга учрыг ойлгуулах зорилгоор гэр бүлийг ёс төртэй баталж, гэрлэлтийн гэрчилгээ



гардуулах ёслолыг зохион байгуулж ирсэн уламжлалтай.

дунд сарын шинийн 17 буюу 2021 оны 9 сарын 22 ны өдөр Сайнцагаан сумын 6 дугаар багийн иргэн Мөнхэрдэнэ, Цэндоо мөн Нинжбадгар, Бямбадорж нарын 2 хосын гэрлэлт батлах ёслолын ажиллагааг зохион байгууллаа. Энэ удаагийн гэрлэх ёслолыг иргэдийн хүсэлтээр гэрт нь ах дүү хамаатан садны дунд нь очиж зохион байгуулснаараа онцлог боллоо.

Намрын

Дундговь аймгийн Тогтвортой амьжиргаа-3 төсөл, Модерн маркет ХХК-тай хамтран ажиллаж аймгийн баруун бүсийн 6 суманд “Бүртгэлийн нээлттэй мэдээллийн өдөрлөг” зохион байгууллаа. Тогтвортой амьжиргаа 3 төслөөс сумдад зохион байгуулсан өдөрлөгийн унаа, бензины зардлыг 100 хувь дааж 680,0 төгрөгийн бодит дэмжлэг үзүүлсэн.

Аймгийн онцгой комисст тус хэлтсийн хамт олон гамшигт хар шороон шуурганд өртсөн малчдад туслах зорилгоор “Нэг өдрийн цалинг” хандив болгож хүргүүлэв. 600,000 /Зургаан зуун мянган төгрөг/ төгрөг хандивласан.




Аймгийн Засаг даргын 2021 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2024 оны үндсэн чиглэлд улсын бүртгэлийн байгууллагаас улсын бүртгэлийн үйлчилгээний танхимд төлбөр үйлчилгээний “Гэрэгэ” машиныг шийдвэрлүүлэх ажлыг тусгаж 3,5 сая төгрөгийн дэмжлэгийг авлаа.

“Цахим үйлчилгээ-2021” сарын аяныг зохион байгуулж Дэрэн, Хулд, Дэлгэрхангай сумдын ЗДТГазар санхүүгийн дэмжлэг үзүүлж хөдөөгийн багийн иргэдэд хууль сурталчилах зорилгоор 1,5 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэж хамтран ажилласан байна. бүртгэлийн үйлчилгээг иргэд цахим орчинд авах мэдлэгийг олгох, И Монгол системийг сурталчлах таниулах, үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэх зорилготой “Цахим бүртгэл-2021” сарын аян зохион байгуулж хөдөөгийн 2037 иргэнд зааварчилгаа, 325 иргэний гар утсанд И-Монгол АПП суулгаж, тус системээс лавлагаа гаргаж, иргэний үнэмлэх захиалах зэрэг үйлчилгээг үзүүлсэн



Аймгийн ЗДТГазар тус хэлтсийн ажиллах нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж 5,0 сая төгрөгийн засвар, ширээ, сандал, зарим тохижилтын ажлыг хийж хүлээлгэн өгсөн.



Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд “Алтай таван богд-2021” аялалд 18 албан хаагч хамрагдсан бөгөөд уг үйл ажиллагаанд орон нутгаас 8,9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Нийт 2021 онд орон нутгаас 18,9 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн байна.




Бүртгэгчийн санаачилгаар УБЕГазрын мэдээлэл технологийн газраас төрөлтийн бүртгэлийн мэдээлэл алдаатай буруу, дутуу бүртгэгдсэн 8200 иргэний жагсаалтыг гаргуулан авч мэдээллийн санд засварлуулах зөрчлийг арилгах ажлыг сумдын бүртгэгч нартай хамтран зохион байгуулж ажилласан бөгөөд улсын бүртгэгчид идэвх санаачлагатай сайн ажилласан. Энэ жилийн төлөвлөгөөнд 2050 бүртгэлийн зөрчлийг арилгахаар тусгасан бөгөөд УБЕГазарт 10 удаагийн албан тоотын хавсралтаар жагсаалтыг хүргүүлж өнөөдрийн байдлаар 102,5 хувь буюу 2100 тө арилгасан.

Энэхүү ажлыг зохион байгуулснаар цахимаас мэдээлэл авч байгаа иргэд, E-mongolia системээс лавлагаа авч байгаа иргэд үнэн зөв мэдээллээр хангагдахаас гадна заавал иргэн холбогдсон үед зөрчлийг арилгах биш урьдчилан зөрчлийг арилгаж ажиллах нь иргэд чирэгдэхээс урьдчилан авч байгаа арга хэмжээ болж байна. Ингэснээр И-Монгол системээр иргэд үйлчилгээ авахад алдаа заахгүй байх боломжоор хангагдаж байна.



Мөнх даатгал компанийн Дундговь аймаг дахь салбарт хамтран ажиллах гэрээ байгуулан Хэлтсийн нийт 28 албан хаагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулав. Байгууллагаас 280,0 төгрөгийн дэмжлэг үзүүлж гэнэтийн ослын болон, хөдөлмөрийн чадвар түр алдалтын төрлөөр даатгууллаа. Ингэснээр албан хаагчдын эрүүл мэнд муудах эмчлүүлсэн тохиолдолд, гэмтэл ослын үед даатгалаас санхүүжилт давхар авах нөхцөл бүрдсэн.

Хэлтсийн ахмад албан хаагчид архи, тамхины эсрэг уриалга дэвшүүлэн цахим орчинд түгээж албан хаагчдын гэр бүлд нөлөөлөх ажлыг хийж 100 хувь тамхи, архины хэрэглээгүй хамт олон боллоо.




Хэлтсийн албан хаагчид Хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг бүрдүүлж бүртгэлийн үйлчилгээг дараалал харгалзахгүй шуурхай үзүүлэхээр "Хаалгаа нээ" аянд.

Авлигагүй Дундговь хөгжинө уриалгад нэгдэж цахим орчинд нөлөөллийн зурагт хуудсыг байршуулан олон улсын авлигын эсрэг өдрөөр зохион байгуулагдсан АХА тэмцээнд оролцлоо.



Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаанд нийт албан хаагчид хамрагдсан. Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлийн шийдвэрээр “ Монгол бичгээ эхлэн суралцах” цахим хичээлийг аймгийн хэмжээнд бүх төрийн албан хаагчдад явуулах зорилгоор “ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД” нэртэй фэйж хуудсанд элсэн монгол бичгийн цахим цуврал сургалтад хамрагдаж байна. Албаны мэдээллийн хавтсыг монгол бичгээр хаяглан, цахим орчинд монгол бичгээ сурах тухай челленжийг зарлаж уг арга хэмжээнд аймгийн хэмжээнд 86 албан хаагч хамрагдсан байна.



Хүний нөөцийн чиглэлээр:

1. Тус хэлтсийн төрийн үйлчилгээний албан хаагчдыг Төрийн албаны ерөнхий шалгалтанд ажлын байран дээр бэлтгүүлэн 3 албан хаагчийг тэнцүүлээ. Ингэснээр хүний нөөцийг төрийн үйлчилгээний албан хаагчдаас бүрдүүлэх боломжийг бий болголоо.
2. Шинээр томилогдсон албан хаагчдыг тойрох хуудсаар албан ажилтай танилцуулах, дадлага хийлгэж мэргэшүүлэх арга хэмжээ авч ажлыг хүлээлцэж хэвшлээ.
3. Архивч, хяналтын байцаагч, ЭХЭУБүртгэгчийг УБЕГазар болон нийслэлийн дүүргийн УБХэлтэст ажиллуулан дадлага хийлгэж харилцан туршлага судлуулан мэргэшүүлэх арга хэмжээг авлаа.
4. Албан хаагчдын ковидын дараах болон урьдчилан сэргийлэх үзлэгт үнэ төлбөргүй бүрэн хамруулж 380,0 төгрөгийн санхүүжилтийг хувийн эмнэлгийн салбараас хөнгөлөлт болгон үзүүлж хамтран ажиллалаа.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ

